

## **“ДОРНОД МОНГОЛЫН ЭРТНИЙ НҮҮДЭЛЧИД”**

*/Урьдчилсан үр дүнгээс/*

### **3.Батсайхан**

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны сургууль, Антропологи-Археологийн тэнхим, *Batsaikhan@num.edu.mn*

**Түлхүүр үг:** Хөлөнбуйр, монгол булаш, дөрвөлжин булаш, хиргисүүр, шагай чөмөг

Солонгосын “Азийн судалгааны төв”-ийн санхүүгийн дэмжлэгээр хэрэгжиж буй “Монголын эртний иргэншил” төслийн хүрээнд 2002 оны зун Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт археологийн хээрийн судалгаа зохион явуулж монголын эртний нүүдэлчийн түүх соёл, угсаа гарвалыг нэхэн судлах, судлаачдын хараанд өртөж байгаагүй дурсгалт газруудыг шинээр илрүүлэн олж цаашид өргөн хүрээтэй малтан судлах ажлын эхлэлийг тавилаа.

Хээрийн судалгааны хугацаанд нийт 9 объект дээр ажилласнаас 7-г нь шинээр илэрүүлэн олж судалгааны хүрээнд анх удаа оруулж байгаа юм. Үүнд:

- I. Өглөгчийн гол /Хэнтий, Батширээт/
- II. Бор булаг /Хэнтий, Биндэр/
- III. Дуурлиг нарс /Хэнтий, Баян-Адрага/
- IV. Шуусын голын адаг /Хэнтий, Баян-Адрага/
- V. Батхаан уул /Дорнод, Хөлөнбуйр/
- VI. Тахилгат /Дорнод, Хөлөнбуйр/
- VII. Цувраа /Дорнод, Хөлөнбуйр/
- VIII. Өгөөмөр I /Дорнод, Хөлөнбуйр/
- IX. Өгөөмөр II /Дорнод, Хөлөнбуйр/

**I объект.** Өглөгчийн хэрмээс баруун урагш 1 км орчим зайдай багавтар байц хадны урд тал. Энэ орчмоос газрын өнгөн хөрсөн дээрээс чuluун зэвсгийн ялтас, цуулдас, зомгол мөн ваар савны хагархай хэсгүүд цөөнгүй олдож байсан тул хадан цохионы урд талд 2x2 м хэмжээтэй сорилтын цооног малтав.

Өнгөн хөрсийг малтаж дараагийн үеийг малтахад чuluун зэвсэг, ялтас, цуулдас ваар савны хагархай хэсгүүд гарч байсан бөгөөд 3-р үеэс цөөн тооны чuluун зэвсгийн зомгол, 4-р үеийг хэсэгчлэн малтахад ямар нэг эд өлгийн зүйл гараагүй. Малтальтын гүн газрын дээд талаараа 40 см гүн болсон.

**II объект.** Биндэр сумын төвийн хойт гармаас баруун тийш 5 км зайдай Онон голын хойт эрэгт орших оройдоо шовгор хадтай уулын урд дэнжийг Бор булаг гэнэ. Дээрх шовгор хадны урд талд нэг дугуй зүүн талд нь уулын усны үерт нэг тал нь эвдэрсэн дөрвөлжин булаш, шовгор хадны арын нахиу дээр нэг, эндээс баруун хойш 200 м орчим газарт жалгын урд тал дээр нэг дөрвөлжин булаш, зүүхэн талд нь цуварсан гурван хонхор байлаа. Энэ уулын араар Батширээт орох замын урд нэг дугуй булаш, замын хойт ухаагийн зүүн энгэр дээр нутгийнхан 100 цэргийн булаш хэмээн домголдог өвөрмөц нийлмэл бүтэц зохион байгуулалттай хиргисүүр зэрэг дурсгалууд байлаа.

Энд хүрлийн үеийн 2 дөрвөлжин булаш малтахад 3-р бүлшнаас хүүхдийн гавал, мөчний зарим хэсгүүд гарснаас ямар нэг өөр эд өлгийн зүйлс олдсонгүй. Харин булшны хашлагын гаднах чuluун дараасын зүүн хэсгээс шавар ваарны хагарч бутарсан олон хэсгүүд олдлоо. Түүнчлэн замын урд талд гадаад хэлбэр хэмжээгээрээ эртний монгол булштай төстэй нэгэн байгууламжийг малтахад дараасны төв доороос ногоон паалантай нарийн хүзүүтэй ваар, том хавтгай төмөр зэвийн хамт олдсон бөгөөд булшны нүх огт байгаагүйгээс үзвэл тахилгын байгууламж бололтой юм. Ийм маягийн байгууламж уг байгууламжнаас баруун тийш 200 м гаруй зайдай газарт замын хойт талд байлаа.

Бор булгын дурсгалуудаас 1-р булшыг онцлон дурдвал зохино. Уг булаш нь уулын орой дахь байц хадны доор орших бөгөөд том хад чuluуг 4 м гаруй голчтой

дугуйруулан өрсний дараагаар дотоод хэсгийг нь өрж тавьсан болох нь тодорхой сайн мэдэгдэж байна. Булшийг цэвэрлэж үзэхэд дараасны төв доороос 2 м орчим урт өргөргийн дагуу зууван дугуй хэлбэрийн нүхний толбо илэрсэн бөгөөд зүүн тал хэсгээс жижиг хүрэл товруунаас өөр өдөр өлгө болон хүний яс гарсангүй. Гэхдээ дараас чулууг цэвэрлэх явцад булшны нүхний зүүн захын дээр адууны толгой болон бусад яс олдож байлаа.

**III объект.** Баян-Адарга сумын төвийн урд талын нарсан ойд Онон гол уруу хандсан уулын ар энгэрт оршино. Уг дурсгалыг 90-ээд оны эхээр Монгол Японы хамтарсан “Гурван гол” экспедицийн шугамаар дэвсгэр зургийг нь хийжээ. Энд нийт 230 орчим булш байгаагийн нилээд хэсэг нь хүннү язгууртын булшууд болно. Одоогийн байдлаар ихэнх булшны дээр мод ургаснаас гадна зарим булшны гадаад хэлбэр дүрс эвдэрсэн байна.

Бид хүннү язгууртын булшны гадаад бүтэц зохион байгуулалтыг судлах зорилгоор эдгээр булшны баруун урд талд нарсан ойн захад орших үүдэвчтэй булшийг бүтэн талбайгаар цэвэрлэн үзсэн бөгөөд гол төв талбайд дахин нэг үе цэвэрлэхэд дугуйвтар хэлбэртэй, бараавтар өнгөтэй булшны нүхний толбо элсэн хөрсөн дээр ялгаран харагдаж байлаа. Уг булшийг дараагийн үлиралд дахин өргөтгөн цэвэрлэхээр орхив.

**IV объект.** Баян-Адрага сумын төвөөс зүүн зүгт 25 км зйтгэл газарт Шуусын гол Ононд цутгах билчириний зүүн талын уулын баруун, баруун урд хормойд нэг бүлэг дөрвөлжин булш түүнчлэн овгордуу том болон дунд зэргийн хэмжээтэй дугуй булшууд байлаа. 10 гаруй метр хамгийн том 2 дугуй булшны баруун захын булшийг голд нь нилээд гүнзгий ухсан, эдгэрсэн ул мөр байлаа. Хоёр дахь булшийг нь том том хавтгай чулуу дэрлүүлэн өрж байгуулснаас гадна бүтэц зохион байгуулалт нь анхны байдлаараа байгаа мэт харагдаж байлаа. Нутгийнхны ярьж байгаагаар ийм маягийн булш Ононгийн ар биеэр байдаг тухай хүүрнэж байсан бөгөөд дээрх тоногдсон булшийг Дэлхийн II дайны дараа монголд хоригдож байсан оросын хоригдлууд ухсан хэмээн ярилцдаг тухай дурсаж байв. Үнэхээр дээрх булшны эдгэрсэн байдлаас үзвэл эртний ор биш болох нь тодорхой байна.

**V объект.** Хөлөнбуйр орох замд Хэрлэнгийн гүүрний хойт талд орших оройдоо хадтай уулыг Батхаан уул гэнэ. Энэхүү уулын урд хормойгоор янз бүрийн цаг үед холбогдох цөөнгүй булш байгааг гүйлгэн ажиглав.

**VI объект.** Хөлөнбуйр сумаас урагш 5 км Сүхбаатар аймгийн Баруун -Урт орох замын баруун талын хадтай хоёр уулын баруун талынхыг Тахилгат уул гэх бөгөөд энэ хавийг нийтэд нь Өгөөмөр гэнэ. Тахилгат уулын зүүн, баруун болон урд энгэрээр гол төлөв дунд зэргийн хэмжээтэй дугуйвтар 130 гаруй булш байхаас гадна баруун хойт хормойгоор маш их тоногдсон ганц нэг хадны оршуулга байлаа. Энд байгаа бүх булшны солбилцол болон хэлбэрийг тодорхойлов.

**VII объект.** Цувраа уул Тахилгат уулын зүүн талд оршино. Энэхүү уулын урд энгэр, зүүн баруун энгэр хормой, мөн уулын дунд хотгор ар хормойд дугуй, дөрвөлжин нийлсэн 80 гаруй булш байх бөгөөд бүх булшны координат, хэлбэрийг тодорхойлов. Дээр дурдсан ар хормойд байгаа том булш нь /10 м гаруй/ дөрвөн тал хашлагатай голдоо хэдэн том чулуун дараастай урд өмнө судлаачдын хараанд өртөөгүй дурсгал бөгөөд ямар цаг үед холбогдох нь тодорхойгүй байна. Үүнээс гадна уулын зүүн урд дундаа 20 см урт эр бэлэг эрхтэн маягийн сийлмэл тэмдэгтэй жижиг хөшөө түүний орчим хэлбэр дүрс нь тодорхойгүй хэсэг чулуун байгууламж байлаа.

Бид энд нийт долоон булш малтан судалснаас нэг байгууламжид оршуулга байгаа ямар нэг ул мөр огт илрээгүй бөгөөд бусад зургаан булшинд оршуулга байлаа.

**VIII объект. Өгөөмөр I.** Хөлөнбуйраас Сүхбаатар аймаг орох замын зүүн талд сумаас 8-10 км зйтгэлтэй урагшаа харсан богино амны дунд хотгорт 20 гаруй хүннү бололтой булшууд байсан бөгөөд урд өмнө нь тэмдэглэгдээгүй байна.

**IX объект. Өгөөмөр II.** Өгөөмөрөөс зүүн зүгт 4 км здайтай зүүн хойшоо харсан богино аманд 10 гаруй хүннү маягийн дугуй булшууд байлаа. Дээрх 2 газрын хооронд 1-2 км орчим здайтай оршино. Эдгээр булшууд нь хэлбэр хэмжээ, орших газрын хувьд хүннү булштай төстэй байгаа боловч нэгэнт малтан судлаагүй учир он цаг, угсаа хамаарлын асуудлыг хөндөн тавих боломжгүй байна. Гэхдээ Дорнод Монголын тал хээрийн бүсэд хүннү булш байх бүрэн магадлалтай.

Түүнчлэн сумын төвөөс зүүн тийш 10 гаруй км здайтай, Хэрлэнгийн урд эрэгт орших Өлзийт уулыг тойроод олон тооны булш, хүн чулуу зэрэг сонирхолтой дурсгалууд байдаг тухай мэдээ бий боловч энэ удаа шалгах боломж гарсангүй.


2002 оны хээрийн судалгаагаар урьд өмнө төдийлөн малтан судлаж байгаагүй зарим ховор тохиолдох дурсгалыг шинээр илрүүлэн олж малтан судлах ажлыг зохион явууллаа. Тухайлбал, Бор булагт малтан судалсан хүрлийн үеийн дугуй булшийг дурдаж болно. Ийм маягийн булш хиргисүүр, дөрвөлжин булштай газарт байдыг судлаачид анзаарсан боловч цаг үе болон тэдгээрийн хооронд ямар харилцаа холбоо байж болох талаар одоогоор нэгдсэн санал дүгнэлтэнд хүрээгүй байна. Гагцхүү оршуулгын зан үйлийн хувьд нас барагчийг аль нэг талаар нь атийлган баруун ба баруун хойт зүгт чиглүүлэн тавьсан байдаг нь хиргисүүртэй адил болохыг судлаачид тэмдэглэсэн байна (Коновалов нар 1995, Эрдэнэбатар 2002). Харин бидний малтан судалсан дөрвөлжин булштай нэг талбайд байх дугуй булшны хувьд тавилт болон зүг чигийг тогтоох бодит хэрэглэгдэхүүн гараагүй боловч нүхний хэлбэр хэмжээ, байрлалаар нь нас барагчийг тэнэгэр байдлаар зүүн зүг харуулан оршуулжээ гэж таамаглаж болохоор байна..

Судалгааны хэрэглэгдэхүүнээс үзвэл дээрх хэв шинжийн булшууд нь хиргисүүр, дөрвөлжин булшт соёлынхны нийгмийн социаль ялгаатай холбоотой байж болох зарим нэг тал ажиглагдаж байгаа боловч эцсийн дүгнэлт хийх хэмжээний дурсгалыг хараахан малтаж судлаагүй байна.

Шуусын голын адагт мөн дээр дурдсан дугуй ба дөрвөлжин булшны хослол ажиглагдсан бөгөөд тэнд 10 м гаруй бусдаас ялгархуйц 2 том булш /нэг нь тоногдсон ул мөртэй/ байлаа. Чухам ийм хэв шинжийн булшуудыг хиргисүүр буюу хиргисүүр маягийн хэв шинжийн дурсгал гэж томъёолох нь бодит байдалд төдийлөн нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, нэр томъёоноос эхлээд дээрх хэв шинжийн дурсгалуудыг малтан судлах судалгааны шинэ арга зүйг боловсруулан хэрэглэхгүйгээр Монгол болон хөрш зэргэлдээх нутгийн хүрлийн үеийн түүх угсаа-соёлын эздрээтэй асуудлыг шат ахисан түвшинд хүргэх боломжгүй болох нь өнгөрсөн жилүүдэд хийсэн судалгаанаас харагдаж байна.

Хүрлийн үед угсаа соёлын үйл явц ихээхэн нарийн түвэгтэй замаар явагдсан бөгөөд түүнд угсаа гарвалын хувьд төрөл ба төрөл бус хэд хэдэн том жижиг овог аймгууд оролцсоноос янз бүрийн ялгараах онцлогтой дурсгалуудыг үлдээсэн байж болох талтай.

Төслийн хүрээнд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын нэгэн гол амжилт бол өмнө өгүүлсэн шинээр олж илэрүүлсэн Хөлөнбуйрын эртний монголчуудын 200 гаруй булштай 2 томоохон оршуулгын газар болно. Эдгээр булшууд уулын доод бэл, дунд ба дээд энгэр газраар уулын урд, баруун ба зүүн энгэр бэлээр оршино. Үүнээс гадна хүрлийн үеийн дөрвөлжин булш 20 гаруй, сийлмэл тэмдэгтэй 1 хөшөө болон цаг үе, хэлбэр төрх нь тодорхойгүй цөөн тооны байгууламж байна. Эдгээрээс онцлон дурдвал зохих нэг дурсгал бол Цувраа уулын ар хормойд. орших 10 м гаруй тэг дөрвөлжин төвдөө хэдэн чулуун дараастай байгууламж юм. Судалгааны хэрэглэгдэхүүнээс үзвэл Өвөр Монголд ийм хэв шинжийн булшыг малтан судлаж киданы үеийн дурсгал хэмээн тодорхойлсон байна. Нөгөө талаар эртний монгол язгууртуудын булшыг өнөө хир малтан судлаагүйгээс гадна гадаад хэлбэр, бүтэц зохион байгуулалт нь ямар байж болох тухай төсөөлөл бидэнд алга. Иймээс уг булшыг киданы дурсгал гэж үзэхгүй.



**Дорнод Монголын эртний нүүдэлчид**

1,2,3. Дорнод аймгийн Хөлөнбуйрийн 18,20,73-р булш.

4,5,6,8,9,10,11. Дорнод Хөлөнбуйрийн 18,20,35,73-р булш төмөр эдлэл, гуравч, Умард Сүн улсын 5-тын зоос. 6. Хэнтий аймгийн Биндэр сумын Борбулагийн 1-р булш, хүрэл товруу

	Буулшины хэв шинж	Буулшины хэмжээ	Нүхний хэмжээ гүн	Чулувун хаашлага	Оршуулга	Зүг чиг	Хүйс	Зэр зэвсэг	Гоёл чимэг лэл	Ваар	Тахилгын мал	Монгол буулш	Бусад буулш	Газрын байрлал
<b>Хэнтий Биндэр Борбулаг</b>														
1-р буулш	Дугуй	480x480	200x75	-	-	3/?/	-	-	-	хүрэл товруу	-	-	Адууны толгой	Дээд урд энгэр
2-р буулш	Дөрвөлжин	340x240	45x150x70	-	3	-	-	-	-	-	-	-	Баруун хормой уулын ар хөтөл	
3-р буулш	Дөрвөлжин	280x200	40x140x50	-	хагархай гавал, шилбэ	3	-	-	-	ваар ны хагар хайхэсэг	-	-	-	-
4-р буулш	Дугуй	300	нүхгүй	-	-	-	-	-	-	төмөр зэв хягад /?	1	-	-	Уулын ар хөтөл
<b>Хэнтий Баян-адрага Дуурлиг</b>														
Дорнод Хөлөнбүйр	Дөрвөлжин Үүдэвчтэй	9x10x6	300x500 нүхний толбо	-	X	-	-	-	-	-	-	-	-	Ар энгэр
<b>Өгөөмөр</b>														
9-р буулш /хоосон/	Дугуй овор	200	-	-	-	-	-	-	-	нук леус хэт	-	-	-	-
18-р буулш	Дугуй	200	40x160x70	+	тэнэгэр бүтэн	3X	Эм?	-	-	түрэвч зэв з хутга хөрөө төмөр эдээл	-	-	-	Дунд энгэр
20-р буулш	Дугуйвтар	380x300	70x45x190x60	+	тэнэгэр бүтэн	X	эр	-	-	шалант дап	-	-	-	Дунд энгэр
22-р буулш	Дугуйвтар	380x210	40x140x60	+	гавал 4 мөч	3X	-	-	-	-	-	-	-	Дунд энгэр
55-р буулш	Дугуй	300	50x180x45	+	Дунд чөмөр, шилбэ, эзэм бүх мөч анх тавилгаар гавал хөдлөлсөн	3XX	-	-	-	шалант	-	-	-	Дээд энгэр
72-р буулш	Дугуй хөшөөтэй	220x240	45x190x100	+	тэнэгэр бүтэн	3X3	-	-	-	-	-	-	-	Дээд энгэр
73-р буулш	Дугуйвтар	320x200	40x25x170x130	+	төмөр хайч	3X	эм	-	-	шалант ботгос дап	-	-	-	Дээд энгэр

Ажиглалтаар, ихэнх булшны гадаад байгууламж анхны байдлаараа байгаа мэт харагдах бөгөөд дотоод зохион байгуулалтын бүх элемент бүрэн бүтэн хадгалагджээ. Гэвч, малтан судалсан зарим булш тоногдож эвдэрсэн байх ба ийм тохиолдолд булшны анхны хэлбэр эвдэрч тодорхой хэлбэр дүрсгүй болсон байлаа.

Булшууд гол төлөв 30-50 см болон түүнээс дээш хэмжээтэй том бахим чулуугаар өрж байгуулсан дугуйвтар ба зууван хэлбэртэй байх ба дундаж өндөр 30-60 см, байна. Мөн хөшөө мэт гозойлгон босгосон чулуутай булш тохиолдоно.

Эртний монголчуудын хөшөөтэй булш Төв, Хэнтий болон Өвөр Байгальд байдгийн заримыг нь малтан судалсан байна. Ийм онцлог бүхий булшыг МЭ YII-X зууны үеийн дурсгал гэж судлаачид үздэг ажээ (Именохоев 1989, Коновалов 1989, Цыбиктаров 1999 ).

Булшны нүх энгийн, ямар нэг нэмэлтгүй дугуйвтар өнцөгтэй, гүн нь 60-130 см орчим байна. Харин нэг онцлох зүйл бол нүхийг тойруулан том бахим чулууг хашлага мэт өрж тавьсан байлаа.

Нас барагсдыг хүйс, нас харгалзалгүйгээр дан нүхэнд хойт ба зүүн, зүүн хойт зүгт чиглүүлэн тэнэгэр байдлаар тавьж оршуулжээ. Нэг тохиолдолд зөвхөн ганц гавал оршуулсан байлаа.

Нас барагсадад зэв, хутга, хөрөө, хэт, гуравч, хайч, зоос гэх мэт эд өлгийг дагуулан тавьсан байх бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүний оршуулгыг эд өлгөөр нь ялан тодорхойлох боломжтой байна. Гэвч, тухайн газарт цөөн тооны булш малтсан тул дээр дурдсан эдийн боловсролын зүйлс нь эд өлгийн бүрдлийг бүрэн төгс төлөөлөх хэмжээнд хараахан хүрээгүйг анхаарах хэрэгтэй. Энэ удаагийн малталаа судалгаагаар хүүхдийн булш огт малтан судлаагүй тул ямар нэг зүйлийг урьдчилан хэлэх боломжгүй байна.

Ихэнх тохиолдолд нас барагсадад хонины шаант чөмөг, дал, богтосьиг аль нэг талд нь дагуулан тавьсан байлаа. Бусад мал болон зэрлэг амьтны яс тавьсан тохиолдол гарсангүй.

Ийнхүү Хөлөн Буйрын булшуудын оршуулгын зан үйлийг байгаа багахан хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан урьдчилан тодорхойлоход ийм байна.

Шагай чөмөгтэй булшуудыг Монгол, Өвөр Байгаль түүнчлэн Алтан ордны улсын нутаг дэвсгэрт малтан судалсан бөгөөд анх ийм шинж тэмдэгтэй булшуудыг Ю.Д.Талько-Грынцевич Буриадын өмнөд нутаг Цөх, Зэд голын савд малтан судалсныг Г.Ф.Дебец энэхүү хэв шинжийн дурсгалуудын оршуулгын зан үйлийн онцлох шинж тэмдэг гэж ялан үзсэн агаад (1926:15) 60-аад оны эхээр А.П.Окладников шаант чөмөгтэй харьцангуй олон тооны дурсгалуудыг харьцуулсны эцэст YIII-X ба түүнээс хожуу үеийн нүүдэлчдийн булш гэх дүгнэлтэд хүрчээ (1976:376,377). Ийнхүү эртний монголчуудын булшийг хөрш Буриадын нутагт XX зууны эхэн үеэс эхлээд харьцангуй сайн судалсан бөгөөд он цагийн ялгаагаар нь хойцегорын буюу түрүү үе (МЭ YII-X) саянтуй буюу хожуу үе (МЭ X-XIY) гэж ангилан түрүү үеийн булшны эд өлгийн зүйлс нь түрэг маягтай байдгийг тэмдэглэсэн байна (Коновалов 1989, Именохоев 1989, Цыбиктаров 1999). Эдгээр булшийг нэгтгэж байгаа нэгэн гол элемент бол шагай чөмөг дагуулах тавих ёс юм.

Монголд, эдүгээ хүртэл 120-130 орчим эртний монголчуудын булшийг малтан судалсан тоо гарч байгаа боловч гол төлөв тохиолдлын байдлаар судалснаас гадна тэдгээрийн өчүүхэн хэсэг нь хэвлэлд нийтлэгджээ. Харин 1980-аад оны дундуур Түүхийн хүрээлэнгээс зохион байгуулж гаргасан “Монголчуудын угсаа гарвалыг судлах палеоэтнографын анги” нилээд ултай судалгаа хийж байсан боловч дөрөв таван жилийн дараа хаагдсанаас гадна судалгааны эх хэрэглэгдэхүүн нь одоо болтол хэвлэн нийтлэгдээгүй байна.

Хэрэглэгдэхүүнээс үзэхэд монголд малтан судалсан эртний монголчуудын булшууд нь их төлөв XIII-XIY зууны үед холбогдож байсан бөгөөд YII-XII зууны үед баттай холбогдох дурсгал малтан судалсан тухай мэдээ баримт тун ховор байна.

Хөлөнбуйрын булшууд нь оршуулгын зан үйлийн олон элемент орших газар, гадаад хэлбэр хэмжээ, нас барагчийг тавих хэлбэр, зүг чиг болон эд өлгийн зүйлээрээ XIII-XIV зууны монголчуудын дурсгалтай ижил байгаа боловч он цагийг урагшлуулан үзэх зарим тал байна. Тухайлбал, 35-р булшинаас Хятадын Умард Сүн улсын (960-1127) 5-тийн зоос гарсан, түүнчлэн эртний булшуудад ажиглагддаг зарим онцлог хөшөө, чулуун хашлага, мөн олон тоогоор нэг бүлэг болон орших гэх мэт талууд нь X-XII зууны нүүдэлчдийн дурсгал байж болохыг байна.

Буриадын нутагт малтан судалсан Саянтийн 160 орчим булштай оршуулгын газрыг эс тооцвол эртний монголчуудын булш гол төлөв хамгийн олон нь 10-15 ихэнх тохиолдолд түүнээс цөөн ганц нэгээр байдаг. Магадгүй энэ байдал нь тухайн үеийн монголчуудын дурсгалыг системтэй судлахад гол биш гэхэд зохих бэрхшээл учруулдаг байж болох юм. Гагцхүү монгол булш ихэнх тохиолдолд маш таруу, цөөн тоогоор байдаг, томоохон бүлэг булштай газар ховор байгаагийн шалтгааныг нийгэм, угсаатан ба он цагийн ялгаа гэх мэт хүчин зүйлийн аль нэгээр нь тайлбарласан зүйлгүй боловч зайлшгүй анхааран судлах асуудлын нэг мөн.

Сурвалжийн мэдээ сэлтээс үзвэл Хэрлэн голын урд биеэр онгуд, жалайр, татар зэрэг эртний нүүдэлчид оршин сууж байсан боловч чухам хэдий үеэс эхлэн суурьшиж байсан тухай заалт сурвалжид гарахгүй байна (Пэрлээ 1959). Гэвч Дорнод монгол нь монгол язгууртнуудад зориулсан хүн чулуун хөшөө, эртний монголчуудын томоохон бүлэг булш зэрэг чухал дурсгалууд орших эртний өлгий нутаг, унаган нутаг хэмээх ойлголт төсөөлөлтэй холбоотой байж болох агаад зарим нэг дам мэдээ заалтыг иш үндэс болгон үзвээс Долнуур хотоос Хэрлэн орох замд Тас ууланд монгол хаадын нэгэн хөрөг байсан бололтой юм (Пэрлээ 2001).

Ийнхүү, Эртний монголчуудын түүх соёл, угсаа гарвалыг мөшгөх хэрэглэгдэхүүн шинээр бий болж байгаа нь “Гурван мөрний язгуурын монголчуудын” нүүдэл суудлын талаарх гадаадын судлаачдын улиг болсон онол, он цагийн асуудлыг бичгийн сурвалжтай харьцуулан судлах найдвартай сурвалж бий боллох төлөвтэй. Хөлөнбуйрын бүлэг булш нь эртний сурвалжит аль нэг монгол овог аймгийн дурсгал мөн бөгөөд монголын эртний түүх, археологи, угсаатны олон зангилаа асуудлыг цогцоор нягтлан судлах өргөн боломжийг бүрдүүлж буй чухал ач холбогдолтой цаашид үргэлжлүүлэн суурин судалгаа явуулах хамгийн тохиромжтой газар болно.

## **Олдворын тодорхойлолт**

Дорнод, Хөлөнбуйр, Өгөөмөр. 73-р булш.. Хадны оршуулга. 2-3 мм голчтой дунгийн ясаар хийсэн цагаан өнгийн сувс 94 ширхэг.

Дорнод, Хөлөнбуйр, Өгөөмөр. 35-р булш.

Дугуй хэлбэртэй, дундаа дөрвөлжин нүхтэй хүрэл зоос. Уг зоосыг Хятадын Сүн улсын (960-1276) үеийнх гэж тодорхойлсон. Иймэрхүү зоос монголын үеийн булшнаас олддог.

Төмөр зэвний модон иш. Төмөр зэв нь зэвэнд идэгдэж бараг дууссан байсан учир хэмжээ нь тодорхойгүй.

Үл танигдах төмөр эдлэлийн хэлтэрхий болон даавууны тасархай

Хэнтий, Биндэр, Бор булаг. 1-р булш. 1,4 см голчтой ардаа хөндлөн сэнжтэй хүрэл товруу. Дангаар эсвэл хэд хэдийг зэрэгцүүлэн бүсэнд хадаж хэрэглэдэг байсан бололтой. Хүрлийн үеийн дөррвөлжин булшнаас цөөнгүй олддог эд өлгийн нэг

Хэнтий, Биндэр, Бор булаг 3-р булш. Бор хүрэн өнгөтэй, том задгай амсартай; шувтан мөртэй, ваарны амсар, мөрний хагархай хэсгүүд, амсарны голч 24 см, ваарны уруул 2,5 см өргөн, дундуураа хос ховилтой, элс, хайрганы хольцтой, хурдасын гаралтай шавраар гараар барьж хийжээ. Үүнтэй төстэй ваарны хагархай хэсгүүд дөрвөлжин булшнаас гардаг.

Хэнтий, Биндэр, Бор булаг. 4-р булш /тахилга/. 10,5 см өндөр, жижиг амсартай, нарийн хүзүүтэй, өргөн мөртэй ногоон паалантай хятад (?) ваар. 18 см урт, сурвалжит, хавтгай зэв. Ийм маягийн зэв XI зуунаас эхлэн нүүдэлчдийн дурсгалуудаас гарч эхэлсэн бөгөөд ялангуяа XIII-XIY зууны үед өргөн тархжээ.

Дорнод, Хөлөнбуйр, Өгөөмөр. 20-р булш. 14 см урт, 1.5 см орчим өргөн, хоёр этгээд нь өргэссен 4 мм зузаан, эврээр хийсэн гуравч /numын бариулын наалт/. Өвөр Байгал, Монголд малтан судалсан X-XIY зууны нүүдэлчдийн дурсгалаас гардаг зэр зэвсгийг төлөөлж тавьдаг эд өлгийн нэг. Х зуунаас эхлээд нумын хийцэд өөрчлөлт гарснаар ясан наалтын тоо цөөрч зөвхөн бариулын наалт үлдсэн бололтой.

Бүтэн үлдсэн нэг зэвний урт 11 см. Үлдсэн 2 зэвний жинхэнэ хэмжээг тогтоох боломжгүй зэвэнд идэгдэн эвдэрсэн байна. Зэвүүд бүгд хавтгай, хэлбэр хэмжээний хувьд адил байна. Ийм хэв шинжийн зэв XI-XIY зууны нүүдэлчдийн зэр зэвсэгт онцгой байр суурь эзэлдэг түгээмэл төрлийн нэг.

Гурван хэсэг хугарсан 15 см орчим урт 1-2 см өргөн төмөр хутга. Мөрний зузаан 4 мм.

5,5 см урт, 1 см өргөн, хоёр талаасаа хугарсан төмөр хутганы хугархай. Мөрний зузаан 3 мм. Сумч хутга бололтой.

10 см урт, 3-3,3 см өргөн төмөр хөрөөний хугархай хэсэг. Хөрөөний ир зарим хэсэгтээ зэвэнд идэгдэн мэдэгдэхгүй болсон боловч хөрөө гэж танигдахуйц олон шүд бүрэн бүтэн үлдсэн байна. Ийм хөрөө монгол булшнаас гарсан тухай мэдээ одоохондоо байхгүй байна. Харин Дуулга уул, Морин толгойн хүннү булшнаас гарч байсан тухай мэдээ байна.

Үл мэдэгдэх хавтгай төмөр эдлэлийн хэсгүүд.

Дорнод, Хөлөнбуйр, Өгөөмөр. 18-р булш. 5.5 см урт, С үсэг маягийн төмөр хэт. Ийм хэв шинжийн хэт Түрэгийн дурсгалууд болон эртний монголчуудын дурсгалаас цөөнгүй гардаг бөгөөд нүүдэлчдийн хөдөлгөөнөөр Дорнод Европ хүртэл тархсан ажээ.

Дорнод, Хөлөнбуйр, Өгөөмөр. 73-р булш. 18 см урт, үйлний төмөр хайч. Монгол, Өвөр Байгалын эртний нүүдэлчдийн булшнаас цөөнгүй гардаг эд өлгийн нэг бөгөөд эмэгтэй хүнд дагуулан тавьдаг.

### **Ном зүй**

Дебец Г.Ф. Могильник железного периода у с.Зарубино-, Бурятиеведение.  
Верхнеудинск 1926. №2

Именохоев. К вопросу о культуре ранних монголов (по данным археологии).  
Этнокультурные процессы в Юго-восточной Сибири в средние века.  
Новосибирск. 1989

Коновалов Б.П. Корреляция средневековых археологических культур  
Прибайкалья и Забайкалья. Этнокультурные процессы в Юго-восточной  
Сибири  
в средние века. Новосибирск. 1989

Коновалов Б.П., Наваан Д. Волков В.В., Санжмятав Г. Керексуры в  
Тосонцэнгэле (Р.Идэр, Монголия) ИКЦА Культуры и памятники бронзового и  
раннего железного веков Забайкалья и Монголии. Улан-Удэ 1995

Окладников А.П. История и культура Бурятии. Улан-Удэ 1976.

Пэрлээ Х. Эртний монголчуудын үхэгсдээ оршуулж байсан зан үйлийн  
асуудалд. Академич Х.Пэрлээ, ЭШӨ т. I, УБ. 2001

Пэрлээ Х. Хятан нар тэдний монголчуудтай холбогдсон нь. УБ., 1959

Цыбикторов А.Д. Бурятия в древности и история (с древнейших времен до XVII  
века) Улан-Удэ 1999.

Эрдэнэбаатар Д. Монгол нутгийн дөрвөлжин булш, хиргисүүрийн соёл. УБ. 2002

### **Summary**

**Z.Batsaikhan**

### **Ancient Nomads of Eastern Mongolia**

*The report presents the findings of archaeological field researches in Eastern Mongolia, which have exposed some historical monuments of Bronze period that are very rarely met in Mongolia and two new objects of the X-XIII century consisting of about 200 burials.*

### **Талархал**

“Дорнод Монгол” төслийг БНСУ-ын Азийн Судалгааны Төвийн санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжүүлэв.